

БАТЛАВ: ШУТИС-ийн ЗАХИРАЛ... Б.ОЧИРБАТ/



**ШУТИС-ийн ХЭМЖЭЭНД КОВИД-19 ХАЛДВАРААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ,  
ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ АВАХ, СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИОН  
БАЙГУУЛАХ УДИРДАМЖ**

2021.09.07

**Нэг. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ**

- 1.1. Энэхүү удирдамжийн зорилго нь Коронавируст халдвар цар тахал “Ковид-19”-өөс урьдчилан сэргийлэх чиглэлээр УОК, НОК-с гаргасан шийдвэр, Боловсрол шинжлэх ухаан, Эрүүл мэндийн сайдуудын хамтарсан тушаал, мэргэжлийн байгууллагууд болон ШУТИС-ийн Захирлын гаргасан тушаалуудыг хэрэгжүүлэх, хичээл сургалтын өдөр тутмын үйл ажиллагааг хэвийн явуулах, багш, ажилтан, оюутнууд, сурагчдыг халдвараас хамгаалагдсан орчинд ажиллах, суралцах, оюутны дотуур байранд амьдрах нөхцлийг бүрдүүлэх, их сургуулийн орчинд халдварын сэжигтэй тохиолдол илэрсэн үед авах хариу арга хэмжээг зохицуулахад оршино.

**Хоёр. ХАМРАХ ХҮРЭЭ**

- 2.1. Энэхүү удирдамжын дагуу хэрэгжүүлэх үйл ажиллагааны зааварчилгаа нь Коронавирусын халдварын нөхцөлд ШУТИС-ийн бүх бүрэлдэхүүн, харьяа сургууль, технологийн коллеж, ерөнхий боловсролын ахлах сургууль, хүрээлэн, салбар тэнхим, МСҮТ, захиргаа, аж ахуй, сургалтын үйлчилгээний нэгжүүдийн үйл ажиллагаанд дагаж мөрдөх үйл явцыг зохицуулна.

**Гурав. НОРМАТИВ ЭШ ТАТАЛТ**

- 3.1. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1 дэх заалт;
- 3.2. Коронавируст халдвар/КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллийг бууруулах тухай хууль;
- 3.3. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны “Боловсролын салбарт хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” 32 дугаар тогтоол;
- 3.4. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах хууль;
- 3.5. УОК-ийн даргын 2021 оны 02-р сарын 22-ны 18 тоот тушаалын хавсралт “Коронавируст халдвар (КОВИД-19)-аас сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах түр журам”;
- 3.6. БШУ-ны Сайдын тушаал. 2021 оны 8 сарын 17-ны өдрийн А/290 тоот тушаалын хавсралт “Их, дээд сургууль, коллежийн сургалтын үйл ажиллагааг зохион байгуулахад мөрдөх түр журам” ;
- 3.7. БШУ-ны Сайд, ЭМ-ийн Сайдын хамтарсан А/292, А/525 тоот тушаалууд;
- 3.8. УОК-ийн 41-р түр тушаал;
- 3.9. ШУТИС-ийн Захирлын 2021 оны 8 сарын 26-ны А/149 тоот тушаалын хавсралт “Өндөржүүлсэн бэлэн байдлын үед сургалтын үйл ажиллагаанд зохицуулалт хийх удирдамж”;
- 3.10. ЭМ-ийн Сайдын 2021 оны 01-р сарын 27-ны А/29-р тушаал.

## **Дөрөв. НЭР ТОМЪЁО, ТОДОРХОЙЛОЛТУУД**

- *Халдварын эх уурхай:* Корона вируст халдвар (КОВИД-19)-ын эмнэлзүйн шинж тэмдэгтэй болон шинж тэмдэггүй хэлбэрээр өвчилсөн хүн.
- *Халдвар дамжих зам:* агаар дуслын болон шууд хавьтлын зам: Өвчтэй хүн ярих, ханиах, найтаах, дуулах зэрэгт амьсгалын замаас 5-10рт хэмжээтэй вирус агуулсан дусал өвчтөний эргэн тойрны 1метр хүртэлх зайд цацагдаж эрүүл хүний ам, хамар, нүдний салстаар халдвар дамжина.
- *Сэжигтэй тохиолдол* - Коронавируст халдварын эмнэл зүйн шинж тэмдгүүд болох халуурах, хуурай ханиалгах, ядарч сульдах, амьсгал давчдах, булчин өвдөх, хоолой өвдөх, толгой өвдөх, бөөлжих, суулгах, хамар битүүрэх зэргээс 3 ба түүнээс дээш шинж тэмдэг илэрсэн хүн.
- *Ойрын хавьтал:* Батлагдсан тохиолдолтой эмнэл зүйн шинж тэмдэг илрэхээс өмнөх 2 хоног, шинж тэмдэг илэрсэнээс хойш 1-14 хоногийн хугацаанд хавьтал болсон эсхүл лабораторийн шинжилгээгээр онош батлагдсан эмнэл зүйн шинж тэмдэггүй хүнтэй онош батлагдахаас өмнөх 2 хоног, батлагдсанаас хойш 14 хоногийн хугацаанд хавьтал болсон хүн.
  - ✓ Коронавирусын халдварын батлагдсан хүнтэй 1.5-2 метрээс дотогш зайд 15 минут, түүнээс дээш хугацаанд нүүр тулж харьцсан хүн
  - ✓ 1 анги, танхим, өрөөнд хамт байсан, 1 ширээнд хамт хооллосон хүн
  - ✓ Хувийн болон нийтийн тээврийн хэрэгслээр 15 минутаас дээш хугацаагаар хамт зорчсон хүн

## **Тав. 2021/2022 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН НАМРЫН УЛИРЛЫН СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИОН БАЙГУУЛАХ**

- 5.1. Коронавируст цар тахлын халдвар, тархалтаас хамааруулан хичээлийг танхимын болон танхимын бус хосолсон хэлбэрээр зохион байгуулна.
- 5.2. 20-40 оюутантай лекц, семинар, лаборатори, практик, бие даалт болон дадлагын хичээлийг танхимаар, 40-өөс дээш оюутантай хичээлийг цахим хэлбэрээр зохион байгуулна.
- 5.3. Анги танхимын багтаамжаас хамаарч 20-40 оюутантай нэг бүлгийг дэд бүлэгт хуваан танхимын хичээлийг зохион байгуулж болно.
- 5.4. Цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор лекцээс бусад төрлийн хичээлийг нэг долоо хоногт танхимд, дараагийн долоо хоногт цахимаар ээлжлэн зохион байгуулахыг зөвшөөрнө.
- 5.5. Танхимын сургалтын үед нэг бүлгээс илэрсэн халдварын сэжигтэй тохиолдол батлагдвал тухайн хичээлийн сургалтыг тодорхой хугацаанд танхимын бус, цахим хэлбэрт шилжүүлнэ. Энэ үед тухайн бүлэгт хамт байсан багш, оюутнууд халдвар илрэх эрсдэлт хугацаанд өөрийгөө тусгаарлан, бусад хичээлдээ танхимаар оролцохгүй.
- 5.6. Хичээлийн анги танхим, лабораторит халдварын тохиолдол батлагдсан нөхцөлд шуурхай ариутгал халдваргүйжүүлэлт хийхтэй холбоотойгоор тухайн анги, танхимд дараагийн цагуудад орох хичээлийг өөр боломжит танхимд (шаардлагатай тохиолдолд цахим хэлбэрт) шилжүүлнэ. Ариутгал халдваргүйжүүлэлтийн хугацаа дууссаны дараа анги, танхимд хичээл орно.
- 5.7. Коронавируст халдвар авсан, эмчилгээ хийлгэж буй профессор багшийн хичээлийг цахимаар явуулах, шаардлагатай үед өөр багшид шилжүүлэн заалгах асуудлыг салбар, тэнхимийн эрхлэгч шуурхай шийдвэрлэн, сургалтын үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангана.

- 5.8. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас сургалтын үйл ажиллагаатай холбоотой гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг нэгжүүд тухай бүр шуурхай хангана.
- 5.9. Номын сангийн уншлагын танхимын ширээг 1-1,5 м зайтай байрлуулж, профессор багш, оюутан суралцагчдад халдвар хамгааллын дэглэм баримтлан үйлчилгээ үзүүлнэ. Гэрээр ном олгох, буцаах үйл ажиллагааг эрүүл ахуй, халдвар хамгааллын горимын дагуу зохион байгуулж, хяналт тавина.

## **Зургаа. ХИЧЭЭЛИЙН БАЙРАНД ХЭРЭГЖҮҮЛЭХ УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ**

### **6.1. Бүрэлдэхүүн сургууль, бүтцийн нэгжүүдийн хэрэгжүүлэх чиг үүрэг**

- 6.1.1. Тухайн бүрэлдэхүүн сургууль 3-с доошгүй хүний бүрэлдэхүүнтэй тандалтын багийг захирлын тушаалаар байгуулж ажиллуулах.
- 6.1.2. Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх санамж, зөвлөмжийг хичээлийн, лекцийн танхим, лаборатори, сургуулийн болон оюутны байрны коридор нийтийн эзэмшлийн талбай, албан тасалгаа, ариун цэврийн өрөө зэрэгт хүний нүдэнд ил харагдахуйц газарт байршуулан, цахим хэлбэрээр хүргэх;
- 6.1.3. Халдваргүйжүүлэх бодис, амны хаалт, нүүрний хаалт, бээлий, гар халдваргүйжүүлэх спиртэн суурьтай бодис, гарын шингэн саван, цэвэрлэгээний материалын нөөцийг бүрдүүлэх;
- 6.1.4. Ариун цэврийн өрөөнд гар угаах нөхцөлийг бүрдүүлж гарын шингэн саван, гар халдваргүйжүүлэх уусмалыг хүрэлцэхүйц хэмжээгээр байршуулах;
- 6.1.5. Хичээлийн байрны орох, гарах хаалга тусдаа тэмдэг тэмдэглэгээтэй, нийтийн эзэмшлийн зам талбайд зай барих тэмдэг, тэмдэглэгээг хийж, гар халдваргүйжүүлэх уусмал байрлуулах;
- 6.1.6. Багш, ажилтан болон оюутан суралцагчдын хоорондоо 1.5 метрээс дотогш зайд харьцахгүй байх боломжийг боломжит түвшинд бүрдүүлэх;
- 6.1.7. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын сэжигтэй тохиолдлыг түр тусгаарлах өрөөг Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/537 дугаар тушаалын 9 дүгээр хавсралтын дагуу зохион байгуулж, хичээлийн байрууд дахь тусгаарлах өрөөний бэлэн байдлыг хангах;
- 6.1.8. (КОВИД-19)-ын түргэвчилсэн оношлуурын нөөц бүрдүүлж, бэлэн байдлыг хангах;
- 6.1.9. Танхимын сургалт эхлэхийн өмнө мэргэжлийн байгууллагаар халдваргүйтгэл, шавьжгүйтгэл, мэргэггүйтгэл хийлгэх, бусад хугацаанд графикийн дагуу халдваргүйтгэлийг мэргэжлийн байгууллагын зөвшөөрсөн халдваргүйтгэлийн бодисоор автомакс, мананцар үүсгэгч ашиглан хийх;
- 6.1.10. Оюутан, сурагчид, багш ажилчдад хүнсний аюулгүй байдлыг өндөр төвшинд хангаж, халуун бүлээн ус уух боломж бүрдүүлэх;
- 6.1.11. Шаардлагатай тохиолдолд сэлгэн ажиллах хуваарийг нэгж бүрээр гаргаж, бүрэлдэхүүн сургуулийн захирлаар батлуулах;
- 6.1.12. Багш, ажилтан, оюутан суралцагчийг олноор хамруулах хурал, зөвлөгөөн, уралдаан, тэмцээн болон бусад арга хэмжээг сургуулийн орчинд зохион байгуулахгүй байх;
- 6.1.13. Хичээлийн байруудад хариуцлагатай жижүүр томилж ажиллуулах;

### **6.2. Багш, ажилтны хэрэгжүүлэх чиг үүрэг, зөвлөмж**

- 6.2.1. Багш, ажилтан өөрөө ойрын хавьтал болсон, эсвэл дараах шинж тэмдгээс 3 болон түүнээс дээш илэрсэн үед ажилдаа ирэхгүй, шууд удирдлагад энэ тухайгаа тухайн өдөрт багтаан мэдэгдэж, харъяа эрүүл мэндийн байгууллагад хандах;

Шинж тэмдэг: 37,1 хэмээс дээш халуурах, ханиалгах, ядарч сульдах, толгой өвдөх, булчингаар өвдөх, хоолой өвдөх, амьсгалын дээд замын үрэвсэл, үнэр амт мэдрэхгүй байх, амьсгаадах, хоолны дуршил буурах, дотор муухайрах, бөөлжих, суулгах, сэтгэл санаа тогтворгүй болох;

- 6.2.2. Багш, ажилтан бүр хувийн хамгаалах хэрэгслийг бүрэн бэлтгэн (амны, нүүрний хаалт, гар ариутгагч г.м), эрүүл мэнд, дархлааг дэмжихэд анхааран, халдвар хамгааллын дэглэмийг ажлын байранд хатуу баримталж, эрүүл мэндийн байгууллагын өгч буй зөвлөмж, санамжыг дагаж мөрдөх;
- 6.2.3. Багш хичээлийн эхний 5 минутанд оюутнуудад халдвар хамгааллын талаар зөвлөмж өгөх;
- 6.2.4. Сургуулийн орчинд багш, ажилтан амны хаалт заавал зүүж хэрэглэх, гарыг бохирдсон тухай бүр савандаж угаах, спиртэн суурьтай халдваргүйжүүлэх бодисоор халдваргүйжүүлэх, бусадтай гар барихгүй байх;
- 6.2.5. Эрүүл мэндийн хувьд харшлах шалтгаан байхгүй тохиолдолд багш, ажилтан ковидын 2 болон 3 тун дархлаажуулалтанд хамрагдах;
- 6.2.6. Багш, ажилтан бал үзэг, цаас, сурах бичиг, дэвтэр, утас, компьютер зэрэг аливаа сургалтын хэрэглэгдэхүүнийг өөр хоорондоо дамжуулж хэрэглэхгүй байх;
- 6.2.7. Багш нарын дунд дамжуулан хэрэглэгддэг сургалтын тоног төхөөрөмжийг байнга ариутган хэрэглэх;
- 6.2.8. Багш хичээл эхлэхээсээ өмнө ангид байгалийн агааржуулалт /цонх хаалга онгойлгох/ хийх;
- 6.2.9. Хичээлийн явцад 6.2.1-д заасан шинж тэмдгүүдээс оюутан, суралцагсдад илэрсэн тохиолдолд тухайн сургуулийн тандалтын багт яаралтай мэдэгдэх;
- 6.2.10. Салбар, тэнхимийн эрхлэгчийн туслах тухайн өдөр танхимаар хичээллэсэн багш нарын хичээлд оюутан, сурагчдын суусан ирцийн мэдээг нэгтгэн, тухайн сургуулийн тандалтын багт хүргүүлэх;
- 6.2.11. Тухайн хичээлийн байр хариуцсан менежер цэвэрлэгээ, үйлчилгээнд тогтмол хяналт тавих.

### **6.3. Оюутан, сурагчдын хэрэгжүүлэх чиг үүрэг, зөвлөмж**

- 6.3.1. Ойрын хавьтал болсон, дараах шинж тэмдгээс 3 болон түүнээс дээш илэрвэл гэрээс гарахгүй, зөвлөх багшид энэ тухайгаа мэдэгдэж, харъяа эрүүл мэндийн байгууллагад хандах;

Шинж тэмдэг: Халуурах, ханиалгах, ядарч сульдах, толгой өвдөх, булчингаар өвдөх, хоолой өвдөх, амьсгалын дээд замын үрэвсэл, үнэр амт мэдрэхгүй байх, амьсгаадах, хоолны дуршил буурах, дотор муухайрах, бөөлжих, суулгах, сэтгэл санаа тогтворгүй болох;

- 6.3.2. Оюутан, суралцагч бүр хичээлд ирэхдээ хувийн бэлтгэлийг заавал хангаж ирэх;  
Үүнд:
  - ✓ 2 цаг тутам солих амны хаалт, ус уух сав, 70%-с дээш спиртэн суурьтай гар ариутгагч эсвэл шүршигч байнга авчрах.
  - ✓ Хувийн эд зүйлсийг бусадтай солилцохгүй байхаар тооцон хичээлд шаардлагатай бэлтгэлийг бүрэн хангаж ирэх;
- 6.3.3. Сургуулийн хичээлийн байранд орох бүрдээ биеийн халууныг заавал хэмжүүлэх;
- 6.3.4. Эрүүл мэндийн хувьд харшлах шалтгаан байхгүй тохиолдолд оюутнууд ковидын 2 тун дархлаажуулалтанд хамрагдах;
- 6.3.5. Хичээлийн явцад 6.3.1-д заасан шинж тэмдгүүдээс илэрсэн тохиолдолд хичээл зааж байгаа багшид мэдэгдэх;
- 6.3.6. Сургуулийн орчинд оюутан, сурагчид амны хаалт заавал зүүж хэрэглэх, гарыг бохирдсон тухай бүр савандаж угаах, спиртэн суурьтай халдваргүйжүүлэх бодисоор халдваргүйжүүлэх, бусадтай гар барихгүй байх;

- 6.3.7. Ойрын хавьтал болсон, танхимын сургалтанд оролцож байх үед нь халдварын тохиолдол илэрч батлагдсан бол тухайн бүлэгт байсан оюутнууд халдвар илрэх эрсдэлт хугацаанд өөрийгөө тусгаарлан, бусад хичээлд танхимаар оролцохгүй байх.

## **Долоо. СЭЖИГТЭЙ ТОХИОЛДОЛ ИЛЭРСЭН ҮЕД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ**

Хичээл сургалтын явцад анги танхим, ажлын байр болон оюутны дотуур байранд Коронавируст халдварын сэжигтэй тохиолдол илэрвэл дараах хариу арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

- 7.1. Хичээл сургалтын явцад болон оюутны дотуур байранд коронавируст халдварын эмнэл зүйн шинж тэмдэг илэрсэн багш, ажилтан, оюутан, суралцагчдыг тандалтын багт мэдэгдэх;
- 7.2. Сэжигтэй тохиолдлын ойрын хавьтлыг тогтоон, тухайн хичээлийн явцад сэжигтэй тохиолдол илэрсэн үед анги, танхим, өрөөнд нь цонх салхивчийг боломжит хэмжээгээр нээж, сэжигтэй тохиолдлыг бүрэн үнэлтэл оюутан, суралцагчдыг өөр хоорондоо харилцуулахгүй, өрөө тасалгаанаас гаргахгүй байх;
- 7.3. Сэжигтэй тохиолдлын онош батлагдсан тохиолдолд анхан шатны болон мэргэжлийн байгууллагаар тухайн голомтын эцсийн халдваргүйтгэл хийлгэх;
- 7.4. Эрүүл мэндийн талаарх яаралтай асуудлаар ШУТИС-ийн Эрүүл мэндийн төв, бүрэлдэхүүн сургуулийн их эмч, харьяа дүүргийн өрхийн эмнэлэг болон дүүргүүдийн тандалтын багуудтай холбоо барих; Үүнд:

БЗД: 19001063, СБД: 70116358, ХУД: 18001200-1-5  
ШУТИС-ийн Эрүүл мэндийн төвийн их эмч: Ц.Ононтуул 99065385,  
А.Түмэннаст 88058969  
МХТС-ийн их эмч: Э.Оюунбилэг 99033209  
МТС-ийн их эмч: Б.Отгонхишиг 99189273  
БУХС-ийн их эмч: Б.Энхтуяа 9924218

## **Найм . ТУСГААРЛАХ ӨРӨӨНҮҮДИЙН БАЙРШИЛ , ТҮҮНИЙ АШИГЛАЛТ**

- 8.1. Сэжигтэй тохиолдлуудыг тусгаарлах өрөөнд түр тусгаарлана.  
Тусгаарлах өрөөний байршил:

1-р байр 1-110 тоот

2-р байр Блок-05

4-р байр 4-105 тоот

5-р байр 5-111 тоот

6-р байр 6-132

Т байр Т-107 тоот

8-р байр В1

7-р байр 7-117 тоот

- 8.2. Тусгаарлах өрөөнд заавал байлгах эд зүйлсийг бүрэн бүрдүүлэх, Үүнд:  
Цэвэр ус, нэг удаагийн аяга, цаасан алчуур, ариун цэврийн цаас, хогийн уут, гар халдваргүйжүүлэгч, эмнэлгийн анхны тусламж үзүүлэх иж бүрдэл байршуулах (амны хаалт, нэг удаагийн халат, бээлий, улавч, нүдний шил, малгай, асуумж хуудас, халдваргүйжүүлэгч уусмал, гар халдваргүйжүүлэгч)

#### **Ес. ЦЭВЭРЛЭГЭЭ, ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭЛТ**

- 9.1. Анги танхим, лаборатори, өрөө тасалгаанд 1.30 цаг тутамд 10 минут агаар сэлгэлт хийх;
- 9.2. Өдөр бүр цэвэрлэгээ халдваргүйжүүлэлтийг тогтмол хийж, ариун цэврийн өрөө, угаалтуур, суултуур, шатны бариул, хаалганы бариул, унтраалга, тоног төхөөрөмж, техник хэрэгслийн гадаргуу зэрэг хүний гар хүрэх эд зүйлсийн гадаргууг 2 цаг тутам халдваргүйжүүлэх бодисын уусмалаар шүршиж, арчин халдваргүйжүүлэх;
- 9.3. Багш, ажилтнууд өөрийн ажлын ширээ, сандал, компьютер, шүүгээ зэрэг албан тасалгаанд буй хүний гар хүрэх гадаргууг 2 цаг тутамд чийгтэй алчуураар арчих, халдваргүйжүүлэх;
- 9.4. Анги танхим, лаборатори, өрөө тасалгааг цэвэрлэж, халдваргүйжүүлсэн талаар үйлчилгээний ажилтан шалгах хуудсанд тэмдэглэгээ хийх;
- 9.5. Цэвэрлэгээнд хэрэглэсэн алчуур, хувин багаж хэрэгслийг цэвэрлэж халдваргүйжүүлсний дараа цэвэр усаар зайлж, хатааж хадгалах;
- 9.6. Нийт багш, ажилтан, оюутан, сурагчид хувийн ариун цэврийг сайтар сахих, нийтийн эзэмшлийн талбай, ариун цэврийн өрөөг зүй зохистой ашиглах, гарын саван, ариун цэврийн цаасыг зохистой хэрэглэж ил задгай нус, цэр, шүлсээ хаяхгүй байх;
- 9.7. Багаж, тоног төхөөрөмж, техник хэрэгслийг ажилтан хооронд шилжүүлэхэд цэвэрлэгээ халдваргүйжүүлэлтийг хийж хүлээлцүүлэх;
- 9.8. Хичээлийн байранд гаднаас нэвтрүүлж байгаа эд зүйлс, тоног төхөөрөмжийг зохих журмын дагуу халдваргүйжүүлж нэвтрүүлэх;
- 9.9. Анги, танхим, өрөөнүүдийн цэвэрлэгээний материалыг /шалны хувин, тоосны хувин, алчуурууд/ хольж, дараагийн ангид хэрэглэхийг хориглох.

#### **Арав. ОЮУТНЫ ДОТУУР БАЙРАНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ**

- 10.1. Сургуулийн хэрэгжүүлэх чиг үүрэг
- 10.1.1. Хичээл сургалтын үйл ажиллагаа танхимаар эхлэхээс өмнө дотуур байрны гадаад, дотоод орчинд цэвэрлэгээ, ариутгал, халдваргүйжүүлэлт хийх;
- 10.1.2. Гар угаагуур болон ариун цэврийн өрөөг 2 цаг тутамд цэвэрлэж, зөвлөмжийн дагуу халдваргүйжүүлэх;
- 10.1.3. Эцэг эхчүүдэд дотуур байранд амьдардаг хүүхдэдээ халдвар хамгааллын дэглэм баримтлахад шаардагдах эд зүйлсээр бүрэн хангаж, гар угаах саван, угаалга цэвэрлэгээний бүтээгдэхүүн, амны хаалт зэргийг хангалттай бэлтгэж өгөх ёстойг сануулж, бэлдүүлэх;
- 10.1.4. КОВИД-19 халдвараас сэргийлэхийн тулд амны хаалт зүүх, гараа савандаж угаах, хүн хоорондын зай барих тухай санамж зөвлөмжийг коридор, уншлагын танхим, мэдээллийн самбар зэрэг оюутны нүдэнд ил харагдахуйц газар байршуулж, тэдгээрийг дотуур байрын орчинд мөрдүүлэх;
- 10.1.5. Дотуур байрны нийтийн эзэмшлийн зам талбайд зай барих тэмдэг, тэмдэглэгээг заавал хийж байршуулах;

- 10.1.6. Гар угаагуурыг байнга устай, савантай байлгаж хүүхдүүд гараа хүссэн үедээ угаах боломжийг бүрдүүлэн, гар угаагуур хүртээмжгүй бол тоог нэмэгдүүлэх;
- 10.1.7. Дотуур байранд оюутнуудыг амны хаалттай нэвтрүүлнэ. Мөн оюутнуудын гарыг халдваргүйжүүлж, биеийн халууныг хэмжих;
- 10.1.8. Ундны цэвэр ус уух нөхцлийг бүрдүүлэх бөгөөд оюутнууд өөрсдийн аяга, усны савыг хэрэглэх;
- 10.1.9. Сургуулийн захиргаанаас цэвэрлэгээний бүтээгдэхүүн, халдваргүйтгэлийн бодисын нөөцийг бэлтгэж өгөх бөгөөд дотуур байрын үйлчилгээний ажилтныг шаардлагатай хувцас, хэрэгсэл (бээлий, амны хаалт, малгай гэх мэт)-ээр хангах;
- 10.1.10. Оюутны дотуур байр болгон тандалтын багийг 3-аас доошгүй хүний бүрэлдэхүүнтэй байгуулах;
- 10.1.11. Оюутны дотуур байр болгон тусгаарлах өрөөг зохих журмын дагуу бэлдсэн байх.

## **10.2. Дотуур байрны эрхлэгч, байр хариуцсан эмчийн хэрэгжүүлэх чиг үүрэг**

- 10.2.1. Тухайн байр хариуцсан эмч дотуур байрны үйлчилгээний ажилчдад халдварт өвчний үед цэвэрлэгээ, халдваргүйтгэл хийх талаар сургалт, зааварчилгаа өгөх;
- 10.2.2. Үйлчилгээний ажилтан нь дотуур байрны нийтийн эзэмшлийн газарт (шал, хаалга, хаалга шатны бариул, гэрлийн унтраалга, ширээ сандал, цонхны тавцан зэрэг) цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийг заавар зөвлөмж, хуваарийн дагуу тогтмол хийх бөгөөд дотуур байрны багш хяналт тавих;
- 10.2.3. Дотуур байрны эрхлэгч нь сурагчдад өөрийн амьдардаг өрөө, тасалгаанд цэвэрлэгээ, агаар сэлгэлт хийх, эрүүл ахуйн дэглэм баримтлах талаар зөвлөгөө өгч, хяналт тавина. Мөн хүүхдүүдийн эрүүл мэндийг ажиглаж, шаардлагатай тохиолдолд тухайн байр хариуцсан эмчид мэдэгдэж, зөвлөмж чиглэл авах;
- 10.2.4. Тухайн дотуур байрны эрхлэгч нь байранд амьдарч байгаа оюутнуудын Ковид-19-ийн өвчлөлийн талаархи мэдээллийг нэгтгэж байр хариуцсан эмчдээ мэдээлэх;

## **10.3. Дотуур байранд амьдардаг оюутны хэрэгжүүлэх чиг үүрэг, зөвлөмж**

- 10.3.1. Ойрын хавьтал болсон тохиолдол болон дараах шинж тэмдгээс 3 болон түүнээс дээш илэрвэл байрнаас гарахгүй, энэ тухайгаа байрны багшдаа мэдэгдэх;  
Шинж тэмдэг: Халуурах, ханиалгах, ядарч сульдах, толгой өвдөх, булчингаар өвдөх, хоолой өвдөх, амьсгалын дээд замын үрэвсэл, үнэр амт мэдрэхгүй байх, амьсгаадах, хоолны дуршил буурах, дотор муухайрах, бөөлжих, суулгах, сэтгэл санаа тогтворгүй болох;
- 10.3.2. Өрөө, тасалгаанаас гарсан хог хаягдлын амыг боож, зориулалтын цэгт хаях;
- 10.3.3. Өрөө тасалгаанд өдөр бүр саван, угаалгын нунтаг хэрэглэн чийгтэй цэвэрлэгээ хийх
- 10.3.4. Ширээ, сандал, шүүгээ зэрэг өрөөнд буй хүний гар хүрэх гадаргууг 2 цаг тутамд чийгтэй алчуураар арчих, халдваргүйжүүлэх
- 10.3.5. Цэвэрлэгээнд хэрэглэсэн шүүр, алчуур, бусад хэрэгслийг сайтар угааж, цэвэр усаар зайлж хатаах
- 10.3.6. Өрөө тасалгаанд 2 цаг тутамд 10-15 минут агаар сэлгэлт хийх;
- 10.3.7. Бусадтай эд зүйлсээ солилцохгүй, дотуур байрны дүрэм журмыг баримтлах.

## **10.4. Оюутны дотуур байранд сэжигтэй тохиолдол илэрвэл авч хэрэгжүүлэх хариу арга хэмжээ**

Оюутны дотуур байранд Коронавируст халдварын сэжигтэй тохиолдол илэрвэл дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

- 10.4.1. Дотуур байранд коронавируст халдварын эмнэл зүйн шинж тэмдэг илэрсэн ажилтан, оюутанг тандалтын багт мэдэгдэх
- 10.4.2. Сэжигтэй тохиолдлын ойрын хавьтлыг тогтоон тухайн, өрөөнд нь цонх салхивчыг боломжит хэмжээгээр нээж, өөр хоорондоо харилцахгүй, өрөө тасалгаанаас гарахгүй байх
- 10.4.3. Тандалтын баг харьяа өрхийн эмнэлэг болон дүүргийн тандалтын багийг дуудна.
- 10.4.4. Сэжигтэй тохиолдлын онош батлагдсан тохиолдолд мэргэжлийн байгууллагаар тухайн голомтын эцсийн халдваргүйтгэл хийлгэх
- 10.4.5. Эрүүл мэндийн асуудлаар харьяа дүүргийн өрхийн эмнэлэг болон дүүргүүдийн танадалтын багтай холбоо барих: БЗД 19001063, СБД 70116358, ХУД 18001200-1-5

## **Арван нэг . ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТ БА ХЯНАЛТ**

- 11.1. Энэхүү удирдамжийн хэрэгжилт, хяналтыг дараах байдлаар хариуцан зохион байгуулна. Үүнд:
  - ✓ *Захиргааны газар, алба:* Удирдамжийн дагуу үйл ажиллагааны хэрэгжилтийг ШУТИС-ийн хэмжээнд удирдан зохион байгуулах, хангах;
  - ✓ *Бүрэлдэхүүн сургуулийн захирал:* Удирдамжийн дагуу үйл ажиллагааны хэрэгжилтийг бүрэлдэхүүн сургуулийн хэмжээнд удирдан зохион байгуулах, хангах;
  - ✓ *Салбар тэнхимийн эрхлэгч:* Удирдамжийн дагуу үйл ажиллагааны хэрэгжилтийг салбар, тэнхимийн хэмжээнд зохион байгуулах, хангах;
  - ✓ *Багш:* Хичээл, сургалтын явцад тухайн анги, танхим, лабораторит халдвар хамгааллын дэглэмийг сахиулах, халдвар хамгааллын талаар оюутанд зөвлөмж өгөх;
  - ✓ *ШУТИС-ийн Эрүүл мэндийн төв, бүрэлдэхүүн сургуулийн их эмч:* Анхан шатны эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх, сэжигтэй тохиолдлыг үнэлэх, халдвараас хамгаалах санамж, зөвлөмж гарган хүргэх, сургалт, сурталчилгааг зохион байгуулах, анхан шатны болон мэргэжлийн байгууллагаар халдваргүйжүүлэлт хийлгэх, хянах, тусгаарлах өрөөний бэлэн байдлыг хангах;
  - ✓ *Маркетинг, олон нийттэй харилцах алба, Оюутны соёл үйлчилгээний алба, ШУТИС-ийн Оюутны холбоо:* Халдвараас хамгаалах, урьдчилан сэргийлэх талаар санамж зөвлөмж байрлуулах, багш, оюутанд цахимаар болон бусад хэлбэрээр тогтмол мэдээлэл хүргэх, сургалт, сурталчилгааг зохион байгуулах;
  - ✓ *Оюутны дотуур байрны эрхлэгч:* Удирдамжийн дагуу үйл ажиллагааны хэрэгжилтийг оюутны дотуур байрны хэмжээнд удирдан зохион байгуулах, хангах;
  - ✓ *Бүрэлдэхүүн сургуулийн тандалтын баг:* БШУ, ЭМ-ийн Сайдуудын хамтарсан А/292, А/525 тоот тушаалаар батлагдсан түр журмын 4.1-т заагдсан чиг үүргийг хэрэгжүүлэх;
  - ✓ *Байр ашиглалт хариуцсан менежер:* анхан шатны болон мэргэжлийн байгууллагаар халдваргүйжүүлэлт хийлгэх, хичээлийн байрны цэвэрлэгээг зохион байгуулах, хянах;
  - ✓ *Бүрэлдэхүүн сургуулийн нярав:* нөөц бүрдүүлэх, хуваарилах ажлыг зохион байгуулах, тусгаарлах өрөөний бэлэн байдлыг хангах;
  - ✓ *Үйлчилгээний ажилтан:* ариун цэврийн өрөөнд гар угаах нөхцлийг бүрдүүлж гарын шингэн саван, гар халдваргүйжүүлэх уусмалыг хүрэлцэхүйц хэмжээгээр байршуулах, сургуулийн орох хаалган дахь гар халдваргүйжүүлэх уусмалын дүүргэлт болон бэлэн байдлыг хариуцах;



- ✓ *Сургалтын мастер, эрхлэгчийн туслах:* анги, танхим, лабораториудын бэлэн байдлыг хангах, тогтмол агаар сэлгэлт хийх, тоног төхөөрөмжийн болон эд зүйлсийг шилжүүлэх үеийн ариутгал хийх;
  - ✓ *Зөвлөх багш:* тухайн ангийн оюутантай холбоотой ойрын хавьтал, өвчилсөн, эдгэрсэн талаарх мэдээллийг авах;
  - ✓ *Бүрэлдэхүүн сургуулийн чанарын менежер:* үйл ажиллагааны хэрэгжилтийн ерөнхий хянах үүргийг хүлээж, аливаа хэрэгжилттэй холбоотой мэдээлэл, зөрчил, дутагдал, яаралтай хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар тухайн бүрэлдэхүүн сургуулийн удирдагач мэдээлэх, шийдвэрлүүлэх.
- 11.2. ШУТИС-ийн бүтцийн бүх нэгжийн удирдлага, албан тушаалтнууд төрийн захиргааны төв байгууллага, мэргэжлийн байгууллагуудаас гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг тухай бүр шуурхай ханган ажиллана.

--- o ---